

ХҮНСНИЙ НОГООНЫ ТАЛБАЙН ТҮГЭЭМЭЛ ТАРХАЛТТАЙ ХОГ УРГАМАЛ

Таримал ургамлын ургацыг бууруулдаг хэд хэдэн гол шалтгаан байдгийн нэг нь хог ургамал юм. Таримал ургамлын тариаланд ургаж ургац, түүний чанарыг бууруулах нөлөөтэй зэрлэг ургамлыг хогийн ургамал гэдэг.

Манай орны ургамлын аймагт нийт 49 овог, 212 төрөлд хамаарагдах 438 зүйл (Г.Цэрэнбалжид, 1996) хог ургамал ургадгаас тариалангийн төв бүсэд 200 гаруй зүйл (В.И.Грубов, 1955) нь тархан ургаж байна.

Таримлын өсөлт хөгжилтийг дарангуйлж ургац, чанарыг нь бууруулж байгаа олон талт нөлөөг хор хөнөөл (Марков, 1972) гэдэг. Тариалангийн талбай болон ХАА-н эдэлбэр газарт ургаж байгаа хог ургамал нь хүний хэрэгцээнд зориулагдсан таримал, хадлан, бэлчээрийн ургац, чанарт муу нөлөөтэй, өөрөөр хэлбэл ямар нэгэн хэлбэрээр хор хөнөөл учруулж байдаг. Эдгээр эдэлбэр газруудын дотроос хог ургамлын хор хөнөөлд хамгийн их нэрвэгддэг нь газар тариалан юм.

Хог ургамлын хор хөнөөл

Хог ургамлуудын үндэсний системийн хөгжил хүчтэй байдгаас таримал ургамлуудаас өрсөж чийг, шим тэжээлийн бодисыг авч ашигладаг. Өндөр иштэй болон газрын дээрх масс ихтэй, агаарын орон зайг их эзэлдэг ургамлууд таримал ургамлыг сүүдэрлэж өсөлт хөгжилтийнх нь нөхцөлийг доройтуулдаг. Дулааны хангамж хангалттай бус бүс нутгийн хөрсний хэмийг 2-4°C хүртэл бууруулж бичил биетний үйл ажиллагаанд муугаар нөлөөлдөг.

Чөдөр тарна, чөдөр сэдэргэнэ зэрэг хог ургамлууд таримлыг ороон хүлж баглан хэвийн өсөлт хөгжилтийг нь алдагдуулдаг байна.

Таримал ургамлын ургацыг бууруулдаг хог ургамлын өөр нэг хэсэг бол шимэгч хог ургамал юм. Манай оронд харьцангуй элбэг тохиолддог ороонго хэмээх хог ургамал нь царгас, хошоонгор, зарим төрлийн шарилжийн ишийг ороогоод тусгай соруулаар ишнээс нь нүүрс усыг сорж амьдардаг.

Хог ургамалтай тэмцэхэд ихээхэн хэмжээний зардал гардаг учраас эдийн засгийн хохирол учруулдаг.

Хог ургамлын биологийн онцлог

Байгаль дээрх бүх төрлийн амьд организмууд орчны тохиромжгүй нөхцөлийг даван туулж амьдрах, үр удмаа үлдээх, өсөж үржих зохилдлоготой байдаг.

Энэ зохилдлого нь ургамлын өөрийнх нь өсөлт хөгжилт болон эд, эрхтнүүдийн онцлогоос гадна байгаль дээр байнга явагддаг үйл хөдлөлөөр хэрэгждэг байна. Хүн хог ургамлыг зориуд устгах үйл ажиллагаа явуулаад байхад мөхөж сөнөхгүйгээр барахгүй харин ч өсөж үржээд байдаг нууц нь тэдгээрийн биологийн онцлогт оршдог. Хог ургамлын ургах биологийн онцлогийг дурдвал:

Implemented by

- Хүрээлэн буй орчны янз бүрийн нөхцөлд соёолох чадвартай.
- Үр нь урт удаан хугацааны турш соёолох чадвараа хадгалдаг.
- Хурдан ургах чадвартай.
- Салхи ба шавьжаар солбицон тоос хүртдэг.
- Нэг ургамал дахь үрийн боловсрох хугацаа харилцан адилгүй.
- Нэг удаагийн ургалтаар маш олон тооны үр өгдөг.
- Олон янзын аргаар үр нь тархах боломжтой.
- Олон наст хог ургамал үрээр үржихийн зэрэгцээ бас ургал эрхтнээрээ үрждэг.
- Ургал эрхтэн нь хөрсөнд гүн нэвтэрдэг учраас түүнийг устгахад ихээхэн бэрхшээлтэй байдаг.
- Нөхцөл нь тохиромжтой үед түргэн ургах ба өрсөлдөх чадвар өндөртэй байдаг онцлогуудтай.

Төмс, хүнсний ногооны тариаланд тархдаг хог ургамлын гол төлөөлөгчид

Нэг наст үет хог ургамал



Тарианы хар будаа

(*Panicum miliaceum* L)



Ногоон хоног будаа

(*Setaria viridis* (L.) Beauv.)

Олон наст үет хог ургамал



Мөлхөө хиаг (голын хиаг)

(*Agropyron repens* (L.) Beauv)

Нэг наст хос үрийн талт хог ургамал



Цагаан лууль

(Chenopodium album L.)



Чөдөр тарна

(Polygonum convolvulus L.)



Татаар сагаг

(Fagopyrum tataricum (L.) Gaertn)



Зэрлэг олс

(Cannabis ruderalis Janisch.)



Урвуу гагдай

(Amaranthus retroflexus L.)



Бөөнөг хамхуул/
өнхрүүш хамхуул

(Corispermum declinatum Steph. ex Ilgin.)

Хоёр наст хос үрийн талт хог ургамал



Царвант шарилж (*Artemisia macrocephala Jacquem*)



Нарийн үхэр гоньд (*Spahallero carpus gracilis (Bess.ex Trev) K.Pol.*)

Олон наст хос үрийн талт хог ургамал



Хөдөөний шаралзгана (*Sonchus arvensis L.*)



Арзгар азаргана (*Cirsium setosum (Willd.) Bieb.*)



Чөдөр сэдэргэнэ (*Convolvulus arvensis L.*)

Ашигласан хэвлэл:

Л.Товуу, Газар тариалан”, УБ, 1980

Б.Дорж нарын бусад “Монголын газар тариалан. Соёмбо нэвтэрхий толь”, УБ, 2018.

Б.Дорж, Д.Ичинхорлоо, “Хог ургамал судлал” 2006.

Эмхэтгэн боловсруулсан:	Герман-Монголын Хамтын Ажиллагааны „Тогтвортой Хөдөө Аж Ахуй“ Төсөл (MNG 19-01)
Хаяг:	Засгийн газрын IХа байр, Энхтайвны өргөн чөлөө 16а, Улаанбаатар 13381, Монгол улс
Мэйл:	project.mn@iakleipzig.de
Вэб хуудас:	www.dmknl.de
Текст	УХЭШХ-ийн Хог ургамал судлалын лабораторийн ЭШАА, Доктор И.Отгонбаатар
Тайлбар	Энэхүү мэдээллийн богцонд багтсан баримт, дүгнэлтийн үнэн зөв байдлыг зохиогч хариуцна. Уг зөвлөмж нь Герман-Монголын хамтын ажиллагааны “Тогтвортой хөдөө аж ахуй” (MNG 19-01) төслийг санхүүжүүлэгч ХБНГУ-ын Хүнс, хөдөө аж ахуйн яамны албан ёсны байр сүүрийг илэрхийлээгүй болно.